



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2019 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2020/34/СТА-ТӨХК

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Аудитор Г.Түвшинзаяа  
Утас: 260512 Цахим хаяг: tuvshinzayag@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Грант торнтон аудит" ХХК  
Утас: 70110744 Цахим хаяг: info@mn.gt.com

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшиний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц, бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	15
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ  
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.НЯМСАМБУУ ТАНАА

2020.03.13 № 06/337  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдэх, авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, тайлант хугацааны зардлыг аккрузел сууриар бүртгэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 11-нээс 2019 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01/136 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах,
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай аюулгүй байдлыг хангах,
- Техникийн найдвартай ажиллагааг ханган, дэвшилтэт техник технологи, оновчтой шийдлийг шинээр нэвтрүүлэх, эдийн засгийн үр ашгийн дээшлүүлэх,
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх,
- Аюулгүй ажиллагааг эрхэмлэх
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, шугам сүлжээ байгуулах,
- Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станцыг барьж байгуулах явдал байна.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Даймонд-05” програм хангамж ашигладаг байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг өндөр гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Компани нь өөрийн үйл ажиллагааны үндсэн болон үндсэн бус орлогоор үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлдэг тул тайлант жилийн зарцуулалтыг батлагдсан зорилтот түвшний дагуу үнэн зөв зарцуулсан эсэхийг тодорхойлохын тулд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 379,285.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 3,793.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,391.78 сая төгрөгөөр буюу 101.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>28,055.0</b>	<b>14,545.4</b>	<b>(13,509.6)</b>
Мөнгөн хөрөнгө	6,064.4	4,070.0	(1,994.4)
Авлага	3,439.6	4,411.7	972.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	12,818.5	202.2	(12,616.3)
Бараа материал	5,732.6	5,861.5	128.9
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>378,726.9</b>	<b>397,628.3</b>	<b>(18,901.4)</b>
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,186.5	1,120.6	(65.9)
Үндсэн хөрөнгө	346,526.3	360,280.3	13,754.0
Биет бус хөрөнгө	29,490.2	29,330.3	(159.8)
Дуусаагүй барилга	1,523.9	6,897.1	5,373.2
<b>Нийт өр төлбөр</b>	<b>350,374.5</b>	<b>351,357.7</b>	<b>983.3</b>
Богино хугацаат өр төлбөр	15,367.7	3,711.6	(11,656.1)
Урт хугацаат өр төлбөр	96,933.7	109,573.0	12,639.3
Засгийн газрын оролцоо (Эздийн өмч)	238,073.1	238,073.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,727.0	46,489.5	(238.5)
Эздийн өмчийн бусад хэсэг	28,810.8	28,810.8	-
Хуримтлагдсан ашиг	(19,131.3)	(14,484.3)	4,647.0
<b>Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>406,781.9</b>	<b>412,173.7</b>	<b>5,391.8</b>

/сая төгрөг/



Авлага дансны үлдэгдэл 972.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Дамжуулах үйлчилгээний авлага 1,072.7 сая төгрөг, хувь хүнээс авах авлага 133.0 сая төгрөг, Капитал банкнаас авах 75.4 сая төгрөг, Баруун бүсийн эрчим хүчний сүлжээ ТӨХК-иас 137.0 сая төгрөг, ЗМЗ-ээс 35.8 сая төгрөг, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-иас 40.5 сая төгрөг нийт 1,566.0 сая төгрөгөөр авлага нэмэгдэж, татвар, нийгмийн даатгалын авлага 130,7 сая төгрөг, аж ахуй нэгж, бусад авлага 460.5 сая төгрөг нийт 591.2 сая төгрөгөөр тайлант оны авлага буурч, найдваргүй авлагын нөөц 2.7 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 128.9 сая төгрөгөөр нэмэгдэж 5,861.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын үлдэгдлийн 38.4 хувь буюу 2,251.7 сая төгрөгийг үндсэн сэлбэг хэрэгсэл, 56 хувь буюу 3,284.7 сая төгрөгийг аваарын нөөц эзэлж байна. Тайлант онд нийт 9,217.8 сая төгрөгийн худалдан авалт хийж, 9,088.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны 1,120.6 сая төгрөгийн үлдэгдэл нь Германы Сэргээн босголт зээлийн банкны Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу “ДЦС-3” ХК-д 311.5 сая төгрөг, “ДЦС-4” ХК-д 230.4 сая төгрөг, “Дархан-ДЦС” ХК-д 578.6 сая төгрөгийн суурилагдсан тоног төхөөрөмжүүдийн зээлийн төлбөр байна.

Үндсэн хөрөнгө батлагдсан төсвөөр худалдаж авсан 10,347.4 сая төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 374 дүгээр тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд эрчим хүчний салбарт бий болсон барилга байгууламж, 2019 оны 286 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон барилга байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авсан 15,914.0 сая төгрөг, их засвар, хөрөнгө оруулалтаар 3,098.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны А-1/2175 дугаар тогтоолоор “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт үнэ төлбөргүй шилжүүлсэн 36.8 сая төгрөг, 2019 оны 407 дугаар, 2019 оны А-1/3482 дугаар тогтоолоор акталсан 1,663.0 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 24.2 хувиар буюу 11,656.1 сая төгрөгөөр буурсан.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 88 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 57 дугаар тушаалд нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор Сонгино хайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 23 хорооны гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаан дамжуулах халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэхэд зориулан эрчим хүчний үйлдвэр дамжуулах болон түгээх сүлжээ барихад шаардагдах хөрөнгийн асуудлыг арилжааны банкнаас авч шийдвэрлэхийг үүрэг болгосны дагуу Голомт банктай 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдөр ЗГ/8145100645 тоот зээлийн гэрээ байгуулсан. Эрчим хүчний яамнаас 2019 онд 5 удаагийн нийт 15,843.0 сая төгрөгийн санхүүжилт авч 1,458.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүү, гүйцэтгэгч Ричвел инженеринг ХХК-д 9,552.0 сая төгрөг, Цагаан хорол ХХК-д 4,833.0 сая төгрөгийг тус тус төлж барагдуулсан байна.

Урт хугацаат өр төлбөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 344, 286, 274, 49 дүгээр тогтоолоор 15,937.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, 49.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэн. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 563 дугаар тогтоолын дагуу 8.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайланд хойшлогдсон орлогын тайлант үед хамаарах 2,712.8 сая төгрөгийн орлогын хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга нийт 366.3 сая төгрөг нь актлагдсан хөрөнгөнд ногдох 239.0 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 2018 оны

хойшлогдсон татварын өглөг, машины түрээсийн зардал, ноогдол ашиг нийт 605.3 сая төгрөгтэй холбоотой байна.

## 2.9. Зорилтот түвшиний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Эрчим хүчний сайдын 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 222 дугаар тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг баталсан байна.

Тайлант онд батлагдсан төлөвлөгөөгөөр 346,922.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 346,922.1 сая төгрөгийн зардал батлагдсан байна.

Үйл ажиллагааны орлого 379,155.0 сая төгрөгт хүрч, төлөвлөгөө 9.3 хувиар буюу 32,232.9 сая төгрөгөөр давсан нь "Оюутолгой" ХХК-тай байгуулсан цахилгаан эрчим хүчний худалдах худалдан авах гэрээний дагуу тайлант онд 1,312.3 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч импортолж, төлөвлөснөөс 95.9 сая кВт цагаар өссөнөөс шалтгаалсан байна.

Харин цахилгаан эрчим хүчний дамжуулалтын орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 3,116.5 сая төгрөгөөр тасарсан нь Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн тарифын саналаас 2,846.9 сая, элэгдлийн зардал 11,162.7 сая төгрөгийг хасаж батлагдсанаас орлого дутуу бүрдсэн байна.

Төлбөрт ажил үйлчилгээний орлого 2,766.1 сая төгрөг, хүүгийн орлого 369.5 сая төгрөг, цайны газрын орлого 245.3 сая төгрөг, тендерийн үйл ажиллагааны орлого 11.4 сая төгрөг, валютын ханшийн бодит бус ашиг 1.2 сая төгрөг, бусад орлого 130.7 сая төгрөг, түрээсийн орлого 42.2 сая төгрөг, хойшлогдсон хөрөнгийн орлого 2,712.6 сая төгрөг, торгуулийн орлого 22.2 сая төгрөгийн орлого олж үндсэн бус үйл ажиллагааны төлөвлөгөөт орлогыг 110.6 хувь буюу 603.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нийт 373,712.0 сая төгрөгийг зарцуулж батлагдсан зардлыг 7.7 хувь буюу 26,789.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Тус компанийн ажиллагсдын цалинг Эрчим хүчний салбарын 2019-2020 оны хамтын хэлэлцээрийн 3.3 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон "хөдөлмөрийн хөлсний итгэлцүүрийн I дүгээр зэрэглэл", 2019-2020 оны Хамтын гэрээний 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 17, 28 дугаар тогтоолоор нийт 20 хувиар нэмэгдүүлсэнтэй холбогдуулан цалин хөлсний зардал 427.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Тайлант онд 220/110/35 кВт-ын Оюутолгой дэд станц, "Оюутолгой" ХХК-ийн уурхайн цахилгаан хангамжийн 220 кВт-ын дэд станцуудыг хооронд нь холбох цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлын хөрөнгийн асуудлыг тарифаар зохицуулан хөрөнгөд авч элэгдэл тооцогдох зарчмаар төлөвлөсөн боловч энэхүү ажил бүрэн дуусаагүй тул үндсэн хөрөнгө дансанд орлогод аваагүйгээс элэгдлийн зардал 7,511.7 сая төгрөгөөр дутуу тооцогдсон байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2019 онд 5,013.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,779.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,343.2 сая төгрөгийн алдааг залруулж, 435.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайланд дараах залруулгуудыг хийлээ. Үүнд:

- “Морьт-Импекс” ХХК-тай байгуулсан 2019/251 тоот ажил үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөр 182.0 сая төгрөг /НӨАТ-гүй/-ийг борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” заалтад нийцээгүй, үнэлгээ ба хувиарлалт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- “Оюутолгой” 220/110/35 кВ-ын дэд станц “Оюутолгой” ХХК-ийн уурхайн цахилгаан хангамжийн 220 кВ-ын дэд станцуудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох барилга угсралтын ажилд гэрээт ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл төлбөр 714.0 сая төгрөгийг тайлант хугацаанд аккрузь сууриар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузь сууриар хөтөлнө”, 14.4.1-14.4.7-дахь заалтад нийцээгүй, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Санхүүгийн болон орлогын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан"-г гаргадаг боловч, өмнөх оны тайлангаар үүссэн 604.4 сая төгрөг, тайлант оны 393.0 сая төгрөг, нийт 1,447.5 сая төгрөгийн “Хойшлогдсон татварын өглөг”-ийг санхүүгийн тайланд тайлагнаагүй, татвар ногдуулах орлогоос хасагдах зардлын түр зөрүүнээс үүдэлтэй хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, хойшлогдсон татвартай холбоотойгоор татварын зардлын нөлөөллийг тооцоогүй тул дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан цэвэр ашиг буруу илэрхийлэгдсэн байна. Энэ нь НББОУС 12.-ын 15-д зааснаар хойшлогдсон татварын өр төлбөрийг гүүдвиллийг анхны удаа хүлээн зөвшөөрөх, ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийг анхны удаа хүлээн зөвшөөрөх (бизнесийн нэгдэл биш; ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ноогдох ашиг (татварын алдагдал)-ын аль алинд нөлөөлөхгүй) -өөс үүссэнээс бусад тохиолдолд, татвар ноогдох бүх түр зөрүүний хувьд хойшлогдсон татварын өр төлбөрийг 39 дүгээр хэсэгт заасны дагуу хүлээн зөвшөөрнө, “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын 5.1-д “Татвар ногдох түр зөрүүнээс үүсч буй татварын нөлөөллийг “Хойшлогдсон татварын өглөг” дансаар зохицуулан бүртгэнэ” гэсэн заалтад нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар залруулагдаагүй 460.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц, бусад чухал асуудал

Монгол Улсын Засгийн газар “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулсан “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын гэрээ”-ний 7.3 дугаар заалт, Эрчим хүчний сайдын 2019 оны 26 дугаар тушаал “Оюутолгой” 220/110/35 кВ-ын дэд станц “Оюутолгой” ХХК-ийн уурхайн цахилгаан хангамжийн 220 кВ-ын дэд станцуудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох барилга угсралтын ажилд шаардагдах 6,941.1 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний зохицуулах хорооноос тус компанийн 2019 оны дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тариф дээр нэмж шийдвэрлэсэн байна.

Дээрх ажлын санхүүжилтийг тус компанийн сар бүрийн мөнгөн урсгалд салган тооцож санхүүжүүлээгүйгээс төсөвт өртгөөр нь шууд орлогоор бүртгэсэн байна. Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдэж байгаа ажлын зарлага нь хөрөнгөөр бүртгэгддэг учраас нягтлан бодох бүртгэлийн бүртгэл хөтлөлт болон НББОУС /СТОУС, хууль, журам зааварт нийцэхгүй байгаа тул санхүүгийн тайлан болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудлыг НББОУС /СТОУС, сангийн сайдын баталсан санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар журамтай нийцүүлэх шаардлагатай байна.

Компани нь 2019 онд Монгол Улсын Засгийн газар болон “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулсан “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын гэрээ”-ний 7.3 дугаар заалт, Эрчим

хүчний сайдын 2019 оны 26 дугаар тушаалын дагуу “Оюутолгой” 220/110/35 кВ-ын дэд станц, “Оюутолгой” ХХК-ийн уурхайн цахилгаан хангамжийн 220 кВ-ын дэд станцуудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Уг ажилд шаардагдах 6.9 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний зохицуулах хорооноос тус компанийн 2019 оны дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифт суулгаж өгсөн байна. Энэхүү ажлын эх үүсвэрийг Улсын төсөвт баталж өгөөгүй тул Эрчим хүчний тухай хуулийн 3.1.7-д заасны дагуу барилга угсралтын ажлын зардлыг НББОУС 16-д заасны дагуу хөрөнгөөр бүртгэж авснаар тайлант онд 5,443.0 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан. Хэрэв ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэвэл ногдол ашгийг төлөх мөнгөн хөрөнгийн хомсдол үүсэх эрсдэлтэй байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 4 дүгээр сарын 09-ний 57 дугаар тушаалд Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэхийг “ЦДҮС” ТӨХК-д үүрэг болгохдоо Улсын хөрөнгө оруулалтаар хийгдэх энэхүү ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний яам болон эрх бүхий дээд байгууллага нь Төрийн өмчит банкны зээлээр шийдвэрлэлгүй арилжааны банкны зээлээр санхүүжүүлэх шийдвэр гаргаснаар 13,304.0 сая төгрөгийн зээл авч, 1,455.0 сая төгрөгийн зээлийн хүү нийт **14,759.0 сая төгрөгөөр** дээрх ажлыг санхүүжүүлсэн байна.

Тус ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний яамны 2019 оны төсөвт баталснаар арилжааны банкнаас авсан зээл, зээлийн хүүг төлж барагдуулсан хэдий ч Засгийн газар болон Эрчим хүчний яам тогтоол, шийдвэртээ дээрх ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Төрийн өмчит банкны зээлээр шийдвэрлээгүйгээс улсын төсвөөс 1,455.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн алдагдал буюу үргүй зардал гарсан тул хойшид эрх бүхий дээд байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансны цахим хуудаст мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn/](http://www.shilendans.gov.mn/) цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2019 оны зорилтот түвшний хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн зорилтот түвшний төсөл, тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

## 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн биелэлт 80 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 435.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 3,793.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Балансын данстай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Говийн бүсийн салбарт дараах асуудал илэрлээ.

- Компанийн Гүйцэтгэх захирал асан Ж.Равдандорж нь тус салбарыг оффистой болоход зориулж 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр "Говийн тэнгэр" ХХК-иас Дундговь аймгийн Мандалговь хотын Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутагт байрлалтай 946 м<sup>2</sup> талбай бүхий хүнсний үйлдвэрлэл, худалдааны зориулалттай объектийг 5876 м<sup>2</sup> газрын хамт 300.0 сая төгрөгөөр худалдан авахаар 13/83 тоот гэрээг байгуулж, 250.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 435.9 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглах боломжгүй байсан тул компанийн шинээр томилогдсон удирдлага хуучин барилгын асуудлаар шүүхэд хандсанаар шүүх хяналтын байгууллага уг барилгыг 141.8 сая төгрөгөөр үнэлж, зөрүү 108.2 сая төгрөгийг Гүйцэтгэх захирал асан Ж.Равдандоржоор буцаан төлүүлэх шийдвэр гарсан боловч тухайн объектын засварт зарцуулсан **435.9 сая төгрөгийг** хууль хяналтын байгууллага шийдвэрлээгүй байна. Иймд уг объектын шүүхийн үнэлгээ болон засварын хуримтлагдсан зардлын нийт 553.5 сая төгрөгийн дүн Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хэвээр байна.
- Мөн Hyundai Trailer-маркын авто чиргүүлийг 90.0 сая төгрөгөөр худалдан авсаныг компанийн шинээр томилогдсон удирдлага энэ суудлаар шүүхэд хандсанаар шүүх хяналтын байгууллага уг авто чиргүүлийг 65.0 сая төгрөгөөр үнэлсэн боловч одоог хүртэл худалдан авсан анхны өртгөөр бүртгэсээр байна. Шүүхийн шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайланд НББОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт"-ын 9-д "ААН нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ямар ийм нэгэн шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно", мөн уг стандартын 59-д "Хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл бууруулна. Ийм бууралт нь үнэ цэнийн бууралт юм" гэж заагдсан байна.

гарз юм" гэж заасны дагуу хөрөнгийн бодит өртөг, нөхөгдөх дүн, үнэ цэнийн бууралтыг тооцож, санхүүгийн тайланд тусгаагүй нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх байна.

**3.1.2. Эрсдэл:**

Үхмэл хөрөнгө бий болж, үргүй зардал гарах, үндсэн хөрөнгийн бодит үлдэгдэл буруу илэрхийлэгдэх

**3.1.3. Өгсөн зөвлөмж:**

ТУЗ болон Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт энхүү асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх, нягтлан бодох бүртгэлд НББОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт" стадартын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах, цаашид Компанийн тухай хуулийн 84.4.3-т "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

**3.1.4. Байгууллагаас өгсөн харив. тайлбар:**

Үнэ цэнийн бууралтыг судлах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах ажлын хэсгийг Гүйцэтгэх захиралын 2020 оны 2 дугаар сарын 28-ны 88 дугаар тушаалаар томилсон. Хэрэгжүүлж ажиллана.

**3.2. Худалдан авалтын гэрээ дүгнэсэн акт, баримт маягттай холбоотой асуудал**

**3.2.1. Илрүүлэлт:**

Компани нь томоохон худалдан авалтыг хийхдээ бэлтгэн нийлүүлэгчээр орон нутгийн салбарт шууд хүргүүлэх нөхцөлөөр гэрээ байгуулдаг байна. Гэвч худалдан авалтын гэрээ дүгнэсэн актанд аль салбар хүлээн авсан нь тодорхойгүй байна.

**3.2.2. Эрсдэл:**

Эд материал шамшигдах, эзэнгүйдэх эрсдэлтэй байна

**3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалтын гэрээг дүгнэхдээ хүлээн авсан салбар нэгжийн байршил болон нэрийг гэрээ дүгнэсэн актанд тодорхой бичиж байх.

**3.2.4. Байгууллагаас өгсөн харив, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хүлээн авч, холбогдох газартай хамтран ажиллана.

**3.3. Төрөөс бодлогын чанартай хийгдэж байгаа ажлын талаар**

**3.3.1. Илрүүлэлт:**

Аудитын тайлангийн 2.11-д “Анхаарал татахуйц бусад чухал асуудалд” дурдсан Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдэж байгаа ажил Монгол улсын Засгийн газрын тогтоол, Эрчим хүчний сайдын тушаалаар гүйцэтгэж буй ажилуудын хөрөнгийн эх үүсвэрийн тарифыг нэг худалдан авагчийн загвараар тусад нь санхүүжүүлээгүйгээс нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь НББОУС/ СТОУС-д нийцэхгүй байна.

**3.3.2. Эрсдэл:**

Улсын төсөвт үргүй зардал гарах, санхүүгийн тайлан, үр дүн буруу илэрхийлэгдэх

**3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Энэхүү асуудлыг эрх бүхий дээд байгууллага /ЭХЯ, ЭХЗХ /-ын удирдлагад танилцуулж, төрийн тогтоол, шийдвэр, бодлого, журмыг НББОУС /СТОУС-д нийцүүлэх талаар анхаарал хандуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018.12.31	2019.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,064,350,439.04	4,069,962,166.97
1.1.2	Дансны авлага	2,530,039,234.27	3,602,748,656.76
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	237,775,834.33	107,707,565.46
1.1.4	Бусад авлага	671,760,052.84	701,280,128.98
1.1.6	Бараа материал	5,732,618,186.66	5,861,507,801.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	12,818,482,983.36	202,204,981.87
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>28,055,026,730.50</b>	<b>14,545,411,301.87</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	346,526,324,288.00	360,280,255,573.21
1.2.2	Биет бус хөрөнгө	29,490,184,982.42	29,330,333,847.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,186,482,398.90	1,120,566,710.22
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,523,910,607.00	6,897,145,233.09
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>378,726,902,276.32</b>	<b>397,628,301,363.92</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>406,781,929,006.82</b>	<b>412,173,712,665.79</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.3	Татварын өр	484,203.67	12,984,938.08
2.1.1.4	НДШ-ийн өглөг	528,589.05	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	14,004,218,618.36	1,691,562,345.62
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,136,000.00	182,115,181.82
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,359,327,377.61	1,824,960,126.36
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>15,367,694,788.69</b>	<b>3,711,622,591.88</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	16,497,493,802.39	14,972,714,123.43
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	450,311,032.75	1,447,550,414.89
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	79,985,910,106.00	93,152,774,453.24
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>96,933,714,941.14</b>	<b>109,573,038,991.56</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,727,970,456.22	46,489,466,517.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	28,810,767,698.94	28,810,767,698.94
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(19,131,287,229.21)	(14,484,251,485.48)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>294,480,519,276.99</b>	<b>298,889,051,082.35</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>406,781,929,006.82</b>	<b>412,173,712,665.79</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
1	<b>Борлуулалтын орлого</b>	<b>337,448,162,079.93</b>	<b>372,853,485,205.03</b>
2	Борлуулалтын өртөг	328,559,682,024.84	360,178,503,743.86
3	<b>Нийт ашиг</b>	<b>8,888,480,055.09</b>	<b>12,674,981,461.17</b>
4	Түрээсийн орлого	32,214,946.28	42,230,578.60
5	Хүүгийн орлого	468,776,275.36	369,464,628.91
8	Бусад орлого	10,600,838,687.83	5,888,556,658.04
10	Ерөнхий ба удирдлагын зардал	9,599,278,278.58	10,623,450,819.50
11	Санхүүгийн зардал	204,851,656.11	202,874,296.91
12	Бусад зардал	9,275,101,214.93	2,697,086,808.83
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	2,405,553.52	809,672.43
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(866,478,132.58)	(9,604,381.53)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>47,006,235.88</b>	<b>5,443,026,692.38</b>
19	Орлогын татварын зардал	46,877,627.52	429,729,784.51
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>128,608.36</b>	<b>5,013,296,907.87</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>128,608.36</b>	<b>5,013,296,907.87</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>128,608.36</b>	<b>5,013,296,907.87</b>

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	115,093,125,058.02	123,888,938,809.41
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	49,085,945,880.81	56,751,707,975.71
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	312,924,716.00	292,380,051.92
1.1.6	Бусад мөнгөн орлого	65,694,254,461.21	66,844,850,781.78
1.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	109,790,937,857.74	109,116,747,318.51
1.2.1	Ажилагсад төлсөн	20,132,117,494.49	22,251,760,202.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,995,754,916.73	6,815,100,230.89
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,890,803,314.99	4,302,463,675.82
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	265,850,057.29	280,044,408.75
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,114,081,154.08	1,528,420,617.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	42,664,500,835.57	54,357,984,417.38
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	21,153,532.00	33,146,804.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,706,676,552.59	19,547,826,961.73
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,302,187,200.28</b>	<b>14,772,191,490.90</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	471,881,529.63	369,464,628.91
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	3,150,000.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	468,731,529.63	369,464,628.91
2.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	2,597,021,315.75	3,059,372,893.26
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,553,389,578.75	2,926,158,231.26
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	36,684,800.00	133,214,662.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	6,946,937.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,125,139,786.12)</b>	<b>(2,689,908,264.35)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	37,452,830.62	1,044,578,184.93
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	34,625,928.52	1,043,329,511.43
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,826,902.10	1,248,673.50
3.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	234,210,801.02	15,121,249,683.55
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	233,789,452.44	15,121,011,288.12
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	421,348.58	238,395.43
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(196,757,970.40)</b>	<b>(14,076,671,498.62)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,980,289,443.76</b>	<b>(1,994,388,272.07)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,084,060,995.28</b>	<b>6,064,350,439.04</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,064,350,439.04</b>	<b>4,069,962,166.97</b>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	228,017,764,005.22	42,559,249,380.19	34,108,978.94	(18,957,916,550.52)	251,653,205,813.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(173,499,287.05)	(173,499,287.05)
3	Залруулсан үлдэгдэл	228,017,764,005.22	42,559,249,380.19	34,108,978.94	(19,131,415,837.57)	251,479,706,526.78
4	Өмчид гаргасан өөрчлөлт	10,055,304,345.82	-	28,776,658,720	-	38,831,963,065.82
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	128,608.36	128,608.36
6	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн өсөлт дүн	-	4,168,721,076.03	-	-	4,168,721,076.03
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн бууралт дүн	-	-	-	-	-
	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,727,970,456.22	28,810,767,698.94	(19,131,287,229.21)	294,480,519,276.99
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(366,261,164.14)	(366,261,164.14)
	Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,727,970,456.22	28,810,767,698.94	(19,497,548,393.35)	294,114,258,112.85
9	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	5,013,296,907.87	5,013,296,907.97
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(238,503,938.37)	-	-	(238,503,938.37)
	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,489,466,517.85	28,810,767,698.94	(14,484,251,485.48)	298,889,051,082.35

ТӨХК-ийн Аудитын Байгууллага  
Э.О.Сүхбат

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/34/СТА-ТӨХК
		Шалгагдсан байгууллагын нэр:	"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК		сая төгрөг

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Компанийн Гүйцэтгэх захирал асан Ж.Равдандорж нь тус салбарыг оффистой болоход зориулж 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр "Говийн тэнгэр" ХХК-иас Дундговь аймгийн Мандалговь хотын Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутагт байрлалтай 946 м2 талбай бүхий хүнсний үйлдвэрлэл, худалдааны зориулалттай объектийг 5876 м2 газрын хамт 300.0 сая төгрөгөөр худалдан авахаар 13/83 тоот гэрээг байгуулж, 250.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 435.9 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглах боломжгүй байсан тул компанийн шинээр томилогдсон удирдлага хуучин барилгын асуудлаар шүүхэд хандсанаар шүүх хяналтын байгууллага уг барилгыг 141.8 сая төгрөгөөр үнэлж, зөрүү 108.2 сая төгрөгийг Гүйцэтгэх захирал асан Ж.Равдандоржоор буцаан төлүүлэх шийдвэр гарсан боловч тухайн объектын засварт зарцуулсан 435.9 сая төгрөгийг хууль хяналтын байгууллага шийдвэрлээгүй байна. Иймд уг объектын шүүхийн үнэлгээ болон засварын хуримтлагдсан зардлын нийт 553.5 сая төгрөгийн дүн Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хэвээр байна.	435.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал  Санхүү эдийн засгийн алба хариуцсан дэд захирал  Ерөнхий нягтлан бодогч	Б.Нямсамбуу  Б.Балдорж  Э.Түмэнжаргал
	Мөн Huindai Trailer-маркын авто чиргүүлийг 90.0 сая төгрөгөөр худалдан авсаныг компанийн шинээр томилогдсон удирдлага энэ суудлаар шүүхэд хандсанаар шүүх хяналтын байгууллага уг авто чиргүүлийг 65.0 сая төгрөгөөр үнэлсэн боловч одоог хүртэл худалдан авсан анхны өртгөөр бүртгэсээр байна.				

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2	Компани нь томоохон худалдан авалтыг хийхдээ бэлтгэн нийлүүлэгчээр орон нутгийн салбарт шууд хүргүүлэх нөхцөлөөр гэрээ байгуулдаг байна. Гэвч худалдан авалтын гэрээ дүгнэсэн актанд аль салбар хүлээн авсан нь тодорхойгүй, хэлбэр төдий үйлдсэн байх магадлалтай байна.		Зөвлөмж өгөх	Худалдан авалт ханган нийлүүлэх  Ерөнхий нягтлан бодогч	Батбаяр  Э.Түмэнжаргал
3	Аудитын тайлангийн 2.11-д "Анхаарал татахуйц бусад чухал асуудалд" дурдсан Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдэж байгаа ажил Монгол улсын Засгийн газрын тогтоол, Эрчим хүчний сайдын тушаалаар гүйцэтгэж буй ажилуудын хөрөнгийн эх үүсвэрийн тарифыг нэг худалдан авагчийн загвараар тусад нь санхүүжүүлээгүйгээс нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь НББОУС/СТОУС-д нийцэхгүй байна.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал  Санхүү эдийн засгийн алба хариуцсан дэд захирал  Ерөнхий нягтлан бодогч	Б.Нямсамбуу  Б.Балдорж  Э.Түмэнжаргал
<b>Нийт дүн</b>		<b>435.9</b>			